



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/21 ДУА-2018/19/СТА-01/ТС Мандагловь хот

Г

7

Зөрчлийг арилгуулах тухай



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дэлгэрхангай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад санхүүгийн тайлан дахь 30,000,000.00 /Гучин сая/ төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Байгууллага иргэдтэй үүссэн материаллаг буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Харилцагч байгууллагатай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.
2. Цаашид дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, үүссэн өглөг, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дэлгэрхангай сумын Засаг дарга О.Батчулуун, нягтлан бодогч Б.Өрнөхбаяр нарт хариуцуулав.



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.